

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024.12.05

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд төлөвлөсөн зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд:

- "үр дүнтэй" 100 хувь;
- "тодорхой үр дүнд хүрсэн" 70 – 100 хүртэл хувь;
- "эрчимжүүлэх шаардлагатай" 30 – 70 хүртэл хувь;
- "үр дүнгүй" 0- 30% үнэлгээг гаргалаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын улсын хорооны Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн байдлаар 1 зорилгын хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилт 93 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" хэрэгжилттэй байна.

Хүснэгт 1. Зорилгын дундаж үр дүн

№	Дэс дугаар	Зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэл хувь
"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД: ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ САЙЖРУУЛНА.			
3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.			
1.	3.3.3.1	Парис-2024" зуны олимп, паралимпын наадамд, олимпын эрхийн төлөөх тэмцээнүүд, бусад олон улсын тэмцээнд оролцох	90%
	3.3.3.2	Дотоодын болон олон улсын тэмцээн, наадам зохион байгуулах	100%
	3.3.3.3	Биеийн тамир спортын байгууламж, талбай, тоног төхөөрөмжөөр хангах	90%
Зорилтын дундаж үнэлгээ			93%

Дөрөв. Дүгнэлт.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан Биеийн тамир, спортын салбарын 3 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 93%-тай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэй байна. Зуны олимп, паралимпын наадам, олимпын эрхийн төлөөх тэмцээнүүд оролцох эрх авах шалгуур үзүүлэлт буюу зорилгот түвшинд хүргэж ажиллахад анхаарах шаардлагатай.

Тав. Зөвлөмж

1. Биеийн тамир, спортын улсын хорооны Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний жилийн эцсийн байдлаар 1 зорилго хүрээнд 3 арга хэмжээний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн дагуу зарцуулсан санхүүжилтийг тодорхой эх үүсвэрийн хамт тайлагнаж байх, тайлагналтад тавих хяналтыг сайжруулж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт зөвлөмж хүргүүлж байна.

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.БАТСҮХ

Д.УРАНБИЛИГ